


ХШУИС-ийн Эрдмийн зөвлөлийн 2016 оны 9-р сарын 12-ны хурлаар батлав.

Эрдмийн зөвлөлийн дарга:  /Н.Баатарбилэг/



## МУИС-ийн ХШУИС-ийн бүртгэлд оруулах дотоодын сэтгүүлүүдийн шалгуур үзүүлэлтүүд, үнэлгээ

### 1. Шалгуур үзүүлэлтүүд

#### 1.1. Сэтгүүлийн агуулга, нэр:

Сэтгүүлийн бодлого, салбар шинжлэх ухааны чиглэл, хэвлэгдэх өгүүллүүдийн утга агуулгын хүрээ тодорхой байна. Нэрэнд агуулгыг тусгах ба бүс нутаг, шинжлэх ухааны сургалт судалгааг эрхлэн явуулдаг байгууллага, салбар сургуулийн нэрийг оруулсан байж болно.

#### 1.2. Эрхлэн гаргадаг байгууллага:

Улсын их, дээд сургууль, Монгол улсын шинжлэх ухааны академийн хүрээлэнгүүд, мэргэжлийн нийгэмлэг холбоод байх

#### 1.3. Редакцын зөвлөл:

Эрхлэгч, техникийн редакторыг оролцуулаад дор хаяж 7 гишүүнтэй, бусад нөөц хянан магадлагчидтай байх. Техник редактораас бусад зөвлөлийн гишүүд докторын зэрэгтэй байх.

#### 1.4. Хянан магадлагаа (Peer review):

Тухайн өгүүллийн бичиглэл, судалгааны арга аргачлал, үр дүн, шинэлэг тал, ач холбогдол, дүгнэлт, шинжлэх ухаанч логик уялдаатай байдлын талаар зөв үнэлэлт болон дүгнэлт хийж чадах, тухайн нарийн мэргэжлийн чиглэлээр судалгаа хийдэг, мэргэжлийн хүмүүсээс бүрдүүлсэн хянан магадлагч нараар уншуулж хэвлэх эсэх талаар дүгнэлт хийлгэдэг байх

#### 1.5. Англи абстракт:

Өгүүлэл англиас өөр хэлээр бичигдсэн тохиолдолд 2 абстракт (тухайн өгүүлэл бичигдсэн хэлээр болон англи хэлээр) байна. Англиар бичигдсэн абстрактын өмнө өгүүллийн нэр, авторууд буюу хувь нэмэр оруулсан судлаачдын нэр, тэдгээрийн харъяалал, абстрактын ард түлхүүр үгүүдийг англиар бичнэ.

#### 1.6. Тогтмолжсон байдал:

- Төлөвлөгдсөн хугацаандаа хэвлэгддэг байх
- Сүүлийн 2 жилд дор хаяж 2 дугаар гаргасан байх

#### 1.7. Ёс зүйн баталгаа:

Сэтгүүлийн вэб хуудас, эсвэл хэвлэлийн эх бэлтгэх шаардлагадаа "хэвлэлийн болон судалгааны ажлын ёс зүйн нийтлэг шаардлагуудыг хангасан (бусдын бүтээл, бүтээлийн хэсэг болон санаа хуулбарлаагүй, оригиналь үр дүнтэй, ашиг сонирхлын зөрчилгүй, үнэн зөв хийгдсэн) бүтээлийг хэвлэнэ" гэсэн утга агуулга бүхий мэдэгдэл гаргасан байх

1.8. ISSN дугаартай байх

1.9. Сэтгүүлийн талаарх мэдээлэл:

Вэб хуудастай буюу вэб хайлтаар илэрдэг, гаргасан дугааруудын мэдээлэл хайлтаар олддог эсвэл олон улсын бүртгэлийн системд бүртгэгдсэн байх



## 2. Үнэлгээ

Сэтгүүлүүдийн дараах тоон болон чанарын шалгуур үзүүлэлтүүдээс оруулан тооцож тухайн сэтгүүлд хэвлүүлсэн өгүүллийн багшийн үнэлгээнд тооцох кредитыг тогтооно. Үүнд:

### 2.1 Сэтгүүлийн (хэвлэлийн) бодлого (35%)


- Тодорхой судалгааны чиглэлд төвлөрсөн
- Редакци/эрхлэгчийн зүгээс баримтлах ойлгомж, үнэмшилтэй үзэл баримтлал/бодлоготой
- Хянан магадлагчдын газарзүйн түгэлт (Олон улсын – өөр өөр тивүүдээс, Олон улсын – нэг тивээс, Үндэсний – Өөр өөр хүрээлэнгүүдээс, Үндэсний – Нэг адил хүрээлэн буюу сургуулиас) өргөн
- Бүтээл хэвлүүлэгчдийн газарзүйн түгэлт түгэлт (Олон улсын – өөр өөр тивүүдээс, Олон улсын – нэг тивээс, Үндэсний – Өөр өөр хүрээлэнгүүдээс, Үндэсний – Нэг адил хүрээлэн буюу сургуулиас) өргөн
- Хянан магадлагааны төрөл (Эрхлэгч шийдвэр гаргадаг, Нээлттэй хянан магадлагаа хийлгэж шийдвэр гаргадаг, Нэг талын нууцлалтайгаар хянан магадлагч мэргэжилтнүүдэд уншуулж шийдвэр гаргадаг, Хоёр талын нууцлалтайгаар хянан магадлагч мэргэжилтнүүдэд уншуулж шийдвэр гаргадаг)
- Англи абстракт
- Өгүүллийн бичигдсэн хэлээс хамааралгүй ишлэлийг англи руу орчуулж бичсэн байх

### 2.2 Өгүүллийн агуулга, чанар (20%)

- Хэл (Англи, Англи болон монгол холимог, монгол)
- Тухайн салбарт оруулах шинжлэх ухааны хувь нэмэр
- Абстрактын ойлгомжтой байдал
- Сэтгүүлийн зорилго, хамрах хүрээтэй нийцэж байгаа байдал
- Ойлгомжтой уншигдах байдал (Хэлний болон дүрмийн талаас)

### 2.3 Сэтгүүлийн нэр хүнд (25%)

- Сэтгүүлд хэвлэгдсэн өгүүллийн ишлэгдсэн тоо
- Эрхлэгчийн нэр хүнд
- Сэтгүүлийн импакт фактор



2.4 Тогтмолжсон байдал (10%)

- Төлөвлөгдсөн хугацаанаасаа хоцролгүй хэвлэгддэг байх (4 буюу түүнээс дээш гаралт хойшлогдсон, 2-3 гаралт хойшлогдсон, 1 гаралт хойшлогдсон, хугацаандаа хэвлэгддэг)

2.5 Он-лайн байх (10%)

- Гарчиг он-лайн байх
- Сэтгүүлийн вэб хуудас англи, эсвэл англи болон монгол хэл дээр байх
- Вэб хуудсийн чанар
- Гол мэдээллийн баазуудад хамрагдсан байх
- DOI нь Cross Ref-тэй бүртгэгдсэн байх
- Бүх агуулга нээлттэй, он-лайн байх

2.6 Үнэлгээг бууруулах үзүүлэлтүүд буюу муу сэтгүүлийн шинж тэмдгүүд (хасах оноо)

- Редакц ба зохиогчид адил институцэд харъяалагддаг байх
- Plagiarism (бусдын бүтээл, бүтээлийн хэсэг болон санаа хуулбарласан)
- Зураг, графикийн чанар муу
- Зөв бичгийн дүрмийн алдаатай
- Шинжлэх ухаанч бус
- Өгүүллүүдийн чанар хоорондоо эрс ялгаатай
- Цахим хуудасны чанар муу (Ажилладаггүй, мэдээлэл худлаа эсвэл хоцрогдсон)
- Сэтгүүл нь судалгааны тодорхой чиглэлд төвлөрөөгүй

**3. Үзүүлэлт үнэлгээг сайжруулах, хэрэгжүүлэх талаар**

3.1 Бүртгэх сэтгүүлийн шалгуур үзүүлэлтийг жил бүр боловсронгуй болгож, шинэчилдэг байх

3.2 Шаардлагатай тохиолдолд тухайн сэтгүүл, эсвэл бүлэг сэтгүүл бүрийг ХШУИС-д бүртгэх эсэх талаар комиссын дүгнэлт гаргуулдаг байх

3.3 МУИС-ийн бүрэлдэхүүн сургуулиудын багш нарын бүтээл тэгш шударгаар үнэлэгддэг байх зарчмын үүднээс ХШУИС-ийн дээрх шалгуур үзүүлэлтүүдийг МУИС-ийн шалгуур үзүүлэлтүүдэд тусгуулж байх

--- оОо ---